



ЛҮН СУМЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

Лавлах зүйл байвал 70272248
дугаарын утаснаас лавлана уу?

АГУУЛГА

ХУУДАС

Дарга, Тэргүүлэх аудитор
Л.Жаргалсайхан
өрөөний утас 70272582

Аудитын менежер
О.Амаржаргал
өрөөний утас 70273465

Шинжээч
Ц.Хишигжаргал
Өрөөний утас 70273204

Аймгийн Аудитын газар
Төрийн байгууллагын ордон

• Аудит хийж дууссан тухай мэдэгдэл	2-3
• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-8
• Гол шийдлүүд	9
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	9
• Аудитын санал дүгнэлт	9

**Төв аймгийн Лүн сумын төсвийн байгууллагууд,
тусгай сангууд 2013 оны Санхүүгийн Тайланд
аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Лүн сумын төсөвт байгууллагууд болон тусгай сангуудын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба Сумын Засаг дарга болон төсвийн шууд захирагч болон Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Лүн сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

**Гол санхүүгийн хяналтууд
хамрагдсаныг тодруулбал:**

Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

**Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр
дүнгээс гарсныг тодруулбал:**

- Орон нутгийн төсвийн татварын орлогыг 68147.5 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 57752.8 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 10394.7 мянган төгрөгөөр буюу 15.2 хувиар дутуу биелүүлсэн байна.
- Цэвэр усны шугаманд холбох тендерт АНУ сервис ХХК шалгарч 13/32 тоот гэрээний дагуу урьдчилгаа 80 хувь болох 26800.0 мянган төгрөгийг шилжүүлж тайланд байгууллагаас авах авлагаар бүртгэсэн байна.
- Тайлант онд ОНХСангийн санхүүжилтэнд 114620.9 мянган төгрөгийг олгосон СТСХэлтсээс ирүүлсэн тулган баталгаажуулалтаар 114620.9 мянган төгрөг байна. Тайлант оны санхүүжилтээс 39699.7 мянган төгрөгийн ажил хийгдсэн 49800.0 мянган төгрөгийн ажил хийгдээгүй байна.
- Мал хамгаалах сангийн өвс, тэжээлийн үлдэгдлийг дансанд тусгаагүй байна.

*ЕМ, Санхүүгийн албанаас
УАГазрын харьяа Төв аймгийн Аудитын*

*Газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа
илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар
тайлбар ирүүлнэ үү*

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх зөрчлүүд материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага тул **Зөрчилгүй санал** дүгнэлт гаргахаар Тэргүүлэх аудиторт санал оруулсан байгаа.

ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын Газрын дарга, Тэргүүлэх Аудитор 2014.03.24-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч, нярав болон бусад албан тушаалтан бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**ҮАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

2014.03.21

Танилцуулга

Лүн сумын 2013 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба сумын Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Лүн сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Лүн сумын Засаг дарга тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Лүн сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Орлого санхүүжилтийн талаар:

Лүн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012 оны 12-р сарын 19-ний өдрийн 06-р хуралдааны 01-р тогтоолоор сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг 68147.5 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 57752.8 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 10394.7 мянган төгрөгөөр буюу 15.2 хувиар дутуу биелүүлсэн байна.

Мөн аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого батлагдсан төлөвлөгөөгөөр 121601.5 мянган төгрөг, гүйцэтгэлээр 124515.2 мянган төгрөг буюу биелэлт 102,3 хувьтай, улсын төсөвт төвлөрүүлэх орлого төлөвлөгөөгөөр 3500.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 8022.0 мянган төгрөг биелэлт 229,2 хувиар тус тус биелэсэн байна.

Төрийн сангийн төлөөлөгчийн гаргаж ирүүлсэн 2013 оны орлого, санхүүжилтийн нэгдсэн тайлангаар /нүүр тайлан/ Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 52960.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Тайлант онд орон нутгийн төсөвт төвлөрөх орлогоор 57752.8 мянган төгрөг төвлөрсөн ба НЕҮ-ний санхүүгийн дэмжлэгээр 255558.3 мянган төгрөг, нийт 313311.1 мянган төгрөг төвлөрч, санхүүгийн дэмжлэгээс ЗДТГазарт 156503.4 мянган төгрөг, ИТХуралд 35057.6 мянган төгрөг, Багт 63997.2 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс ЗДТГазарт 57650.8 мянган төгрөг буюу нийт 313209.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож үлдэгдэл 101.9 мянган төгрөг орлогын дансанд үлдсэн.

Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 484817.2 мянган төгрөг, Цэцэрлэгт 221990.2 мянган төгрөг, Эмнэлэгт 227815.6 мянган төгрөг, Соёлын төвд 65732.5 мянган төгрөг нийт 1000355.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг нэгтгэсэн байна. Дээрх байгууллагуудын жилийн эцсийн зарцуулаагүй төсвийн үлдэгдэл 14227.2 мянган төгрөгийг, НҮҮйлчилгээний байгууллагуудын оны эцсийн зарцуулаагүй үлдэгдэл 5305.8 мянган төгрөгийг тус тус татан төвлөрүүлсэн байна

Халамжийн сангийн санхүүжилт 144155.1 мянган төгрөгийг халамж үйлчилгээний санд төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 107616.1 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 32984.0 мянган төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 1870.0 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн зардалд 1685.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 28422.5 мянган төгрөг, Сургууль 3543.8 мянган төгрөг, Соёлын төвд 6592.6 мянган төгрөг 38558.9 мянган төгрөгийн орлого, 29254.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 9304.8 мянган төгрөгийн үлдэгдэлийг мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд нэгтгэсэн.

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор Соёлын төв 1073.9 мянган төгрөг, ЭМТөв 321.5 мянган төгрөг, Сургууль 595.2 мянган төгрөг, нийт 1990.6 мянган төгрөг нэгтгэгдсэн байна.

Сум Хөгжлийн Санд 50000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн ХЭДСангийн данснаас төвлөрсөн , эргэн төлөлтөөс 46642.0 мянган төгрөг төвлөрч тайланд онд 102800.0 мянган төгрөгний зээл олгогдож 2000.0 төгрөгийг ИТХ-ын шийдвэрээр Авдрант хайрхан ХХК-д сумын өндөрлөг босгох ажлын хөлсөнд олгосон байна.

Мөнгөн хөрөнгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар оны эхэнд эм эргэлтийн сан 1246.4 мянган төгрөг, Мал хамгаалах сан 125.7 мянган төгрөг , Байгаль хамгаалах санд 589.1 мянган төгрөг , Нөхөн сэргээх барьцаат санд 975.0 мянган төгрөг , Сум хөгжүүлэх санд 50024.5 мянган төгрөг нийт 52960.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 72762.2 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 101.9 мянган төгрөг, эм эргэлтийн сан 1764.9 мянган төгрөг, Нэмэлт төсвийн санхүүжилтийн дансны үлдэгдэл 9304.8 нийт 83933.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаатай болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн баталгаагаатай тохирч байна.

Авлага, өглөгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар Оны эхэнд 104775.3 мянган төгрөгийн авлага, оны эцэст 259379.3 мянган төгрөгийн авлагатай нэгтгэгдсэн ба оны эхнээс авлага 154604.0 мянган төгрөгөөр өссөн ба жилийн эцсийн нийт авлагын 208971.4 мянган төгрөгийн буюу 80,5 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Өглөг оны эхэнд 63.9 мянган төгрөг, оны эцэст 4890.2 мянган төгрөгийн өглөгтэй нэгтгэгдсэн байна. Оны эцэст ЗДТГ-ын 2928.2 өглөг мянган төгрөг нь нийт өглөгийн 59.8 хувийг , Соёлын төвийн түлш халаалтын өглөг 1517.0 мянган төгрөгний өглөг нь 31 хувийг тус тус эзэлж байна

Бараа материал

Сумын нэгдсэн тайлангаар Бараа материалын данс нь оны эхэнд 87973.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 228186.1 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 228824.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, жилийн эцэст 87334.9 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 5616529.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 167707.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж 984.2 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, жилийн эцэст 5783253.0 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл 179864.2 мянган төгрөг үлдэх өртөг 3028150.0 мянган төгрөг байна

Тусгай зориулалтын сангууд

Сумын хэмжээнд 6 сан үйл ажиллагаа явуулж байгаа ба эм эргэлтийн сангаас бусад сан Төрийн сангийн харилцах дансаар гүйлгээ хийгдэж хянагддаг байна. Сангуудыг тодруулахад:

Байгаль хамгаалах сангийн талаар:

Тус сангийн харилцах данс нь оны эхний үлдэгдэл 589.1 мянган төгрөг байснаас тайлант оны турш 7570.2 мянган төгрөгний орлого санхүүжилт төвлөрч бүрдэл болсон 13ширхэг төлбөрийн даалгавраар 5607.1 мянган төгрөг зарцуулж дансанд 2552.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгаль хамгаалах сангийн эх үүсвэрийг дараахь байдлаар бүрдүүлсэн байна. Үүнд:

Аймгийн санхүүжилтээр байгаль хамгаалах нөхөн сэргээх зардалд 5430.0 мянган төгрөг Монгол тур resort ХХК-наас отгын төлбөр 1500.0 мянган төгрөг 640.2 мянган төгрөг нь хогийн савны үнэ зэрэг нийт 7570.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2013 оны аймгийн төсвөөс 5430.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг ирүүлснээс батлагдсан төлөвлөгөөний дагуу дараах зүйлд зарцуулсан байна. Үүнд:

1. Хуучин хогийн цэгийг түрж булаах ажилд 2910.0 мянган төгрөг
2. Хангайн булгийн эх хашиж хамгаалахад 465.0 мянган төгрөг
3. Нохой устгах зардалд 585.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж

Нийт 3960.0 мянган төгрөгийг зарцуулж 1470.0 мянган төгрөг сангийн үлдэгдэлд үлдсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

Орон нутгийн хөгжлийн сангийн 141452400 тоот дансыг Төрийн санд нээж тайланд онд 114620.9 мянган төгрөгийн орлого, 89499.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж жилийн эцэст харилцах дансанд 25121.2 мянган төгрөгний үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Орлогыг тодруулахад улсын төсвийн санхүүжилт 114620.9 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна. Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх Хөрөнгө оруулалтын эрэмбэлсэн жагсаалтыг сумын ИТХурлын 05-р хуралдаанаар 2013.04.05-ний өдрийн 06 тоот тогтоолоор 11 төсөл хөтөлбөрт 198.4 сая төгрөгөөр баталсан. Аймгийн хэмжээнд олгох санхүүжилт буурсантай холбогдуулан сумын ИТХурлын 2013.12.19-ний өдрийн 01 тоот тогтоолоор 8 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 167.2 сая төгрөгийг баталсан байна.

Тайлант онд ОНХСангийн санхүүжилтэнд 114620.9 мянган төгрөгийг олгосон СТСХэлтсээс ирүүлсэн тулган баталгаажуулалтаар 114620.9 мянган төгрөг байна. Тайлант оны санхүүжилтээс 39699.7 мянган төгрөгийн ажил хийгдсэн 49800.0 мянган төгрөгийн ажил хийгдээгүй байна. Хөрөнгө оруулалтын хийгдсэн ажлыг тодруулахад:

1. ЗДТГ-ын шинэ байрны зураг төсөв хийлгэхэд 42797.0 мянган төгрөг төсөвлөгдснөөс 33899.7 мянган төгрөгөөр хийгдсэн. Тендерийн урилгыг ТГТ ХХК, ЭН ЭЙ ПИ ХХК, Синчи Ойл ХХК-нуудад тус тус хүргүүлж харьцуулалтын аргаар ирүүлсэн материал үнийн саналыг

харгалзан ЭН ЭЙ ПИ ХХК хариуцан хийлгэх үнийн саналыг дэмжин гүйцэтгэгчээр хариуцан ажилласан.

- ЭН ЭЙ ПИ ХХК –нд зургийн үнэ ажлын хөлсөнд / гэрээний № 13/ - 25037.1 мянган төгрөг
 - Ленд тест ХХК-д геологийн үнэлгээ хийлгэх /гэрээний № 18 / - 900.0 мянган төгрөг
 - Дөрвөн гүн ХХК-д Барилгын гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөв хийлгэхэд / Гэрээний № ДГ-/01/2013 / - 6000.0 мянган төгрөг
 - Барилга хөгжлийн төвд Барилгын экспертиз үнэ / гэрээ № х/13-1189 / 1802.7 мянган төгрөг
 - Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-д холбооны техникийн нөхцөлд 110.0 мянган төгрөг
 - Аймгийн орлого төвлөрүүлэхэд 50.0 мянган төгрөг нийт зураг төсвийн үнэ 33899.7 мянган төгрөг зарцуулагдсан байна. ЗДТГ-ын шинэ байрны Зураг төсвийг ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна.
2. Улсын баяр наадам тэмдэглэн өнгөрүүлэх зардалд 5.0 сая төгрөг төсөвлөгдөж 5.0 сая төгрөг зарцуулсан.
3. Хогийн цэгийг хашаажуулах тендерийн урилгыг нээлттэй заралж иргэн Ч.Батсайхан, Ш.Жүрмэддорж ,Энхталын хүлэг ХХК, Донхор ХХК-нуудад урилга хүргүүлсэн. Тендерийн материалыг иргэн У.Батмөнх, Ц.Бираадорж , Ч.Батсайхан нарын хамтарч ирүүлсэн тендерийн материал шалгарч иргэн У.Батмөнхөд хогийн цэгийг хашаажуулах /Гэрээний № 2 / дагуу 10 сая төгрөг зарцуулж холбогдох материалыг хавсаргажээ. Гэвч уг тендерийг гүйцэтгэгч нар эцсийн санхүүгийн материалыг дутуу бүрдүүлж өгөх дутуу , комиссын гишүүдийн гарын үсэг дутуу гэсэн шалтгаанаар хөрөнгийг ЗДТГ-т бүртгэлгүй хувь хүмүүсээс авах авлагаар бүртгэсэн байна.
4. Алтансүлдэт мөнх ХХК-д гэрээгээр 5.0 сая төгрөгний / гэрээний № 01 / халуун усны 2 өрөөг шинээр гаргаж засварлаж тохижуулах ажлыг гүйцэтгүүлэхээр олгож ажил нь дуусгавар болоогүй учир 5.0 сая төгрөгийг тайланд байгууллагаас авах авлагаар бүртгэсэн байна.
5. Гудамжны гэрэлтүүлэг засварын ажлыг 800.0 мянган төгрөгөөр иргэн С.Чимэдрэгзэд, Б.Батжаргал нарын мэргэжлийн хүмүүсээр гүйцэтгүүлж 2013 оны 12 сарын 19-ний 01 тогтоолоор тодотгон батлуулж зарцуулжээ.
6. Лүн сумын төрийн байгууллагуудыг цэвэр усны шугаманд холбох тендерийн урилгыг АНУ сервис ХХК, Энержистер ХХК, Агро алтай ХХК-нуудад хүргүүлж тендер шалгаруулах комиссын саналаар тендерт АНУ сервис ХХК шалгарч 13/32 тоот гэрээний дагуу урьдчилгаа 80 хувь болох 26800.0 мянган төгрөгийг шилжүүлж тайланд байгууллагаас авах авлагаар бүртгэсэн байна.
7. Сургууль дотуур байрны дотор талын цэвэр усны шугамын ажлыг Ану сервис ХХК-ны тавьсан бага үнийн саналыг үндэслэн гэрээ байгуулж 8.0 сая төгрөг олгосныг ажил нь гэрээний дагуу хугацаа болоогүй учир /гэрээний № 02/ байгууллагаас авах авлагаар бүртгэсэн байна.

Мал хамгаалах сангийн талаар:

Тайлант хугацаанд мал хамгаалах сангийн харилцахын эхний үлдэгдэл 125.7 мянган төгрөг байсан ба тайлант онд 3238.8 мянган төгрөг төвлөрч 2142.1 мянган төгрөг зарцуулагдаж 1222.4 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна. Үүнд:

Аймгийн мал хамгаалах сангаас онцгой байдлын шатахуунд 1.0 сая төгрөг , өвсний үнэ 2238.8 мянган төгрөг төвлөрч өвсний фондын сахиулын цалинд 1055.1 мянган төгрөг, онцгой

байдлын шатахууны зардалд 1087.0 мянган төгрөг тус бүр зарцуулагдсан байна. Мал хамгаалах сангийн өвс, тэжээлийн үлдэгдлийг дансанд тусгаагүй байна.

Сүм хөгжүүлэх сангийн талаар:

Сүм хөгжүүлэх сан нь оны эхэнд 50024.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба санхүүгийн дэмжлэг 50000.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдсэн ба зээл, зээлийн хүүний эргэн төлөлтөөс 46642.0 мянган төгрөг нийт 96642.0 мянган төгрөг төвлөрсөн ба 104800.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэнээс 25 хүнд зээл олгосон байна. Сангийн үлдэгдэл 41866.5 мянган төгрөг тайланд үлдэгдэлтэй байна.

Байгаль орчин нөхөн сэргээлтийн сангийн талаар:

Тус санд гүйлгээ гараагүй оны эхэнд 975.0 мянган төгрөг байсан нь үлдэгдлээр тусгагдсан байна.

Гэмт хэргээс урьд чилан сэргийлэх сангийн талаар:

Тус санд сумын ИТХурлын ГХУСэргийлэх зардал болох 2363.3 мянган төгрөг шилжүүлж, Оюунлаг-өөрчлөлт сургалтанд 300.0 мянган төгрөг, шатахууны зардал 549.6 мянган төгрөг, хэсгийн төлөлөгчийн томилолт 80.0 мянган төгрөг, сурагчдын дунд зохиосон хууль сурталчилах тэмцээний зардалд 408.9 мянган төгрөг нийт 1338.5 мянган төгрөг зарцуулж 1024.8 мянган төгрөг үлдсэн байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах
- Санхүүгийн тайлан гаргалт уялдаа холбоог сайжруулах
- МУ-ын ЗГазрын 2012.11.09-ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

1. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн алдаануудыг төсөвт байгууллагуудад залруулсан ба нэгтгэлд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

2. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

3. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31 –нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.03.25